

БАТЛАВ
ШИНЭЖИНСТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА *Б.БАТЭРДЭНЭ*

ГҮЙЦЭТГЭГЧ
ЗАРАА 1 ДҮГЭЭР БАГИЙН

ИРГЭН

Л.Эрдэнэчулуун /Л.ЭРДЭНЭЧУЛУУН/

ЗАХИАЛАГЧ
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ШИНЭЖИНСТ СУМЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Л.Батхуяг /Л.БАТХУЯГ/

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН ХАЛУУН УСНЫ
АЖЛЫН ЗАХИАЛАГЧ ГҮЙЦЭТГЭГЧИЙН
ХООРОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭ**

2024-03-13

Дугаар: БХА ШЖСЗДТГ/20240601015

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Нэг талаас **Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг дарга түүний Тамгын газрын дарга** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас тус сумын Зараа 1 дүгээр багийн иргэн **Л.Эрдэнэчулууны** ирүүлсэн үнийн саналыг хүлээн зөвшөөрч (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2024 оны 03 дугаар сарын 13-ний өдөр энэхүү **ГЭРЭЭГ** (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1.2 Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль, Монгол улсын төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу Халуун усны засвар хийх ажлын захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

1.3. Захиалагч нь Баянхонгор аймгийн **Шинэжинст сумын “Халуун усны засвар хийх”** ажил БХА ШЖСЗТГ/20240601015-ыг (цаашид “ажил” гэх) **20000000/хорин сая /** төгрөгөөр хийж гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨР ТӨЛӨХ НӨХЦӨЛ

2.1. Гэрээний нийт дүн: **20000000 / хорин сая /** төгрөг үүнийг **сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны хөрөнгө оруулалтаас 20000000 / хорин сая / төгрөгөөр** санхүүжилтийг гэрээнд заасан хуваарийн дагуу олгож, уг “Халуун усны засвар”-ын ажлыг бүрэн дуусгаж ашиглагдахгүй байгаа халуун усыг ажиллахад бэлэн болгоно.

Гэрээ байгуулж хүчин төгөлдөр болсон өдрөөс гүйцэтгэгчийн ирүүлсэн хүсэлтийг хүлээн зөвшөөрч, захиалагчтай харилцан тохиролцож 80%-ийн санхүүжилтийг олгож, үлдэх 20 хувийг ажлыг бүрэн дуусгаж хүлээлгэн өгсөний дараа гэрээнд заасны дагуу олгоно.

2.2. Захиалагч нь ажлын гүйцэтгэл, тоо хэмжээ, ил далд ажлын актыг фото зургаар баталгаажуулснийг үндэслэн гүйцэтгэлээр нь гэрээ болон захиалагчийн ирүүлсэн ажлын даалгаврын дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавьж санхүүжүүлэх ба магадлашгүй ажлын зардал **400000**,-Захиалагчийн албаны хяналтын зардал **400000** зардлуудыг тус тус суутгана.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

3.1. Гүйцэтгэгч нь Баянхонгор аймгийн **Шинэжинст сумын “Халуун усны засвар”-ын** ажлын техникийн тодорхойлолт, ажлын даалгаварын дагуу 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эхэлж, 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор ажлыг бүрэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгнө.

3.2. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

3.3 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

3.4 Гэрээний тусгай нөхцөл;

3.5 Техникийн тодорхойлолт; Ажлын даалгавар

3.6 Ажлын тоо хэмжээ;

3.7 Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ЭРХ ҮҮРЭГ

4.1 Захиалагч болон гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

4.2 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчсөн талаарх мэдэгдлийг хүлээлгэн өгсөний дараагаар 30 хоног, эсхүл захиалагчийн бичгээр зөвшөөрөн сунгасан хугацаанд багтаан мэдэгдэлд дурдсан зөрчлийг арилгах үүргийн гүйцэтгэлийг хангаагүй тохиолдолд Захиалагч өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй.

4.1.3 **Халуун усны засварын** ажлын шаардлагатай ажлын даалгавар өмнөх техник эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгаа, зэрэг холбогдох баримтыг бэлтгэн гүйцэтгэгчид өгөх.

4.1 Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажлын гүйцэтгэлийг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

4.2 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХҮЛЭЭХ ЭРХ ҮҮРЭГ

5.1 Ажил гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

5.2 Ажлын гүйцэтгэлийг шалгах, хянах, мөн хэрэгжүүлэх явцад алдаа илэрвэл түүнийг үнэ төлбөргүй шуурхай шийдвэрлэж өгөхийн зэрэгцээ тухайн ажилтай холбогдох хариуцлагыг хүлээнэ.

5.3 Гүйцэтгэгч нь гэрээний дагуух ажил үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлттэй байдлаар гүйцэтгэх ёстой бөгөөд тоног төхөөрөмж, машин механизм болон материаллын хувьд аюулгүй, үр дүнтэй болон зүй зохист арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллах үүрэгтэй.

5.4 Захиалагч нь гэрээний ерөнхий нөхцөлд заасны дагуу ямар нэгэн маргаан үүсээгүй үед гэрээний дагуу төлбөл зохих аливаа төлбөрийг гүйцэтгэгийн ажлын гүйцэтгэл, бичгээр гаргасан төлбөрийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор төлөөгүй тохиолдолд гүйцэтгэгч өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй.

Гүйцэтгэгч нь **"Халуун усны засвар"-ын** ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн

ажилдаа барилгын тухай хуулийн 12.4-ын дагуу 3 жилийн хугацаанд чанарын баталгаа гаргаж өгнө.

АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Хийгдэх засвар	Материал	Тоо хэмжээ	Тавигдах шаардлага
1	Хаалга солих	Төмөр\бүргэд\	1ш \120:200см\	Сайн чанарын бүргэд хаалга суурилуулах
2	Цонх солих	Вакум	2ш \120:150см\ 1ш \150:150см\	3 ширхэг вакуум цонхыг сольж халуун усны стандартад нийцүүлэн суурилуулах
3	Паар солих	Орос паар	1ш \120см\ 4ш \100см\ 5ш \50см\	
4	Халаалтын шугам солих	Труба	52м \32-ын\	32.20-ийн трубагаар хийнэ
5	Цэвэр усны шугам солих	PPR-	42м \20-ын\	Хуучин шугамыг сольж PPR-аар хийх
6	Ус халаах төхөөрөмж суурилуулах	Пойлур	1ш \500л\	Шаардлагат нийцүүлэн хийх
7	Душны өрөөний шалны пильта засварлах	Пильта	20ш \30:40\	Хэсэгчилж засах
8	Гадна дотор пассат засварлах			Шавар, замаск, имульс хийж өнгө үзэмж сайжруулах
9	Дээвэр засварлах			Халуун усны
10	Бохирын цооногийг засварлах			стандартын дагуу засварлах

ЗУРГАА.БУСАД

6.1 Захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд ямар нэгэн маргаан үүсвэл тэр маргааныг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд хэрэв ийм журмаар шийдвэрлэх боломжгүй бол маргааныг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

6.2 Энэхүү гэрээг 3 хувь үйлдсэн бөгөөд талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсанаар гэрээ хүчин төгөлдөр болно.

6.3 Энэхүү гэрээ нь Гүйцэтгэгчийн бэлдсэн тайланг хэлэлцэж, гэрээ дүгнэсэн акт үйлдэж талууд гарын үсэг зурж баталсанаар дуусгавар болно.



ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
 ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
 Л. БАТХУЯГ
 ХАРИЛЦАХ УТАС 88709405
 Хаяг: ШИНЭЖИНСТ СУМ ЭХЭН
 ХАВЦГАЙТ БАГ
 ХАРИЛЦАХ БАНК: ТӨРИЙН САН
 ДАНС: 100031752400

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЗАРАА 1 ДҮГЭЭР БАГИЙН ИРГЭН

Л. Эрдэнэчулуун
 Л. ЭРДЭНЭЧУЛУУН

Хаяг: БАЯНХОНГОР АЙМАГ ШИНЭЖИНСТ
 СУМ "ӨНДӨРЛӨГ ХОРООЛОЛ 2-204
 УТАС – 88306011

ХАРИЛЦАГ БАНК: **Хаан банк:**

ДАНСНЫ ДУГААР: **5241032781**

РД-BC86070111

erdenechuluunlhagva52@gmail.com

Даянхонгор аймгийн Шинэжинст
сумын ЗДТД Тэдэрт халуун
усны барилгын засварын
үнийн саналыг хурцүүлж нь:

Шинэжинст сумын иргэн Аагда овогтой
Эрдэмтцүүлэн шийш бие орон нутгийн хөрөнгийн
сангийн хөрөнгөөр хийгдэх халуун усны барилгын
засварын афлог хийгч үийгэтлэх хүсэлтэй
байна. Хийгдэх афлууд: Тэднэ дотор замал, гэрвэр-
ийн засвар, халаалт, үзвэр усны шугам, цона
хаалга самна афлог ОНХ сангийн 20 сая
төгрөгт багтаан хийх үнийн саналыг хурцүүлж
байна.

Үнийн санал хурцүүлсэн

Л. Эрдэмтцүүлэн

2024 оны 03 сарын 07

Утас: 88306011